

  
**МОНГОЛ УЛС**  
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**  
**ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 29 өдөр

Дугаар A/119

Мандалговь

Г Зохион байгуулалтын арга хэмжээ  
авах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 78 дугаар тогтоол, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны 120 дугаар тушаалын 4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Коронавируст (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 06.00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 06.00 цаг хүртэл сунгасугай.
2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлж удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Боловсрол, соёл урлагийн газар (А.Мөнхтуяа), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), эрүүл ахуй, халдварт хамгааллын дэглэмд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) нарт тус тус үүрэг болгосугай.
3. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд 15 суманд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр нэвтэрч байгаа автомашин, иргэдэд тавих хяналт, шалгалтыг эрчимжүүлж, зайлшгүй шаардлагаар голомтын бус нутгаас нэвтэрч байгаа иргэдийн PCR шинжилгээний хариуг сайтар нягтлан шалгаж, түргэвчилсэн шинжилгээнд хамруулан нэвтрүүлж, тусгаарлан ажиглах байранд авч 7 хоног хяналт тавьж, шинжилгээний дүнг үндэслэн гэрийн ажиглалтад шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.



481210028